# ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧ

In partnership with Canada

The Asia Foundation

EPCRC
ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Мэдээллийн товхимол

2023 ОН - ДУГААР 3



## "Олон улсын худалдааны ерөнхий сургалт"

Видео хичээл

Дэлхийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэд хэрэгжиж буй Экспортыг дэмжих төслөөс бэлтгэсэн видео хичээлүүдтэй танилцана уу.

### "Олон улсын худалдааны ерөнхий сургалт"

Хөтөлбөр:

1. Монгол-Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр
2. Монгол Солонгосын эдийн засгийн түншлэл
3. Япон, БНСУ-ын хорио цээрийн шаардлага
4. Европын холбооны хөнгөлөлтийн систем
5. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АPTA)

Видео хичээл үзэх

### "Гадаад худалдааны ерөнхий сургалт"

Хөтөлбөр:

1. Экспортын цикл
2. Экспортын менежмент
3. Экспортын баримт бичиг
4. Инкотермс 2020
5. Олон улсын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ
6. Олон улсын худалдааны хэлэлцээрүүд
7. Монгол Улсын татвар, гаалийн эрх зүйн орчин

Видео хичээл үзэх

## Хаан банк, BPN
## “ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР” 2023 СҮҮЛИЙН ЭЛСЭЛТ




BPN болон ХААН Банк хамтарсан жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн удирдлагын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээг цогцоор нь олгох “Хөгжлийн хөтөлбөр“ ээлжит элсэлтээ авч эхэллээ.
Бүртгэлтэй холбоотой мэдээллийг 95954295 утсаар холбогдон авах боломжтой.

## АСРАХУЙН ЭДИЙН ЗАСАГ

Гэртээ хүүхдээ хардаг ээжүүд гэхэд сарын 50 мянган төгрөгийн цалинтай. Өндөр настай аав, ээжээ удаан хугацаанд асрах бол эмэгтэйчүүд ажлын байраа орхихоос өөр аргагүй болдог. Энэ мэтчилэн асрахуйн ажлын гол ачаалал эмэгтэйчүүдэд ноогдож, үүнийг нь нийгэм жам ёсны үүргээ гүйцэтгэж байгаа мэтээр хүлээн авдаг хэвээр байна. ...

Нийтлэлийг унших



Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв
## “ДЭЛХИЙН АВЬЯАС, УР ЧАДВАРЫН ТАЙЛАН 2023” судалгааны үр дүнгээс

Швейцар дахь Дэлхийн өрсөлдөх чадварын төв болон Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн зүгээс “Дэлхийн авьяас, ур чадварын тайлан 2023”-ыг танилцуулав. 2023 оны судалгаанаас харахад авьяас, ур чадварын эрэмбээр Швейцар улс тэргүүлсэн хэвээр байна. Авьяас, ур чадвар хамгийн сул орнуудаар Венесуэл (62-рт), Бразил (63-рт), Монгол (64-рт) тус тус эрэмбэлэгджээ.




Монгол Улс ерөнхий үнэлгээ 23.18 онootойгоор 64 улсаас 64-рт эрэмбэлэгдэж сүүл мушгисан. Авьяас, ур чадварын ерөнхий эрэмбэ буурахад бага боловсролын сурагч-багшийн харьцаа (63-рт), эрүүл мэндийн дэд бүтэц (62-рт), ажилчдын урам зориг (63-рт), амьдралын чанар (63-рт), шударга ёс (63-рт), санхүүгийн ур чадвар (64-рт), чадварлаг менежерүүд (64-рт), их сургуулийн боловсрол (64-рт) гэх мэт үзүүлэлтүүд хойгуур эрэмбэлэгдсэн нь нөлөөлжээ.



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

**“Макро эдийн засгийн тойм“ 2023/08 сар**




ДНБ, 2023 оны эхний хагас жилд 6.4 хувиар өссөний -1.7 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 3.9 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.3 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 3.5 нэгж хувийг үйлчилгээний салбар, 0.4 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна.

Дэлгэрэнгүй унших

| Макро үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023.VIII | 2022.VIII | 2023.VII | Өмнөх сараас | Өмнөх улирлаас | Оны эхнээс | Өнгөрсөн жилийн мөн үеэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ДНБ 2023 оны 2-р улирал | их наяд ₮, оны үнээр | 30.4 | 23.1 | - | - | - | - | 6.4% ▲ |
| Инфляц | хувь | 10 | 14.4 | 9.2 | -0.2% ▼ | - | 6.6% ▲ | -4.4 нэгж хувиар ▼ |
| Ажилгүйдлийн түвшин, 2023У2 | хувь | 5.8% 2023 оны У2 | 7.8% 2022 оны У2 | 5.8% 2023 оны У2 | - | -0.8% нэгж хувиар ▼ | - | -2.0% нэгж хувиар ▼ |
| Төсвийн тэнцэл | тэрбум ₮, өссөн дүнгээр | 1818 | -900 | 1360 | 458 ▲ | - | - | 2718 ▲ |
| Ам.долларын ханш | төгрөг | 3469.98 | 3185.70 | 3442.35 | 27.63 ▲ | - | - | 284.28 ▲ |
| Гадаад худалдааны тэнцэл | сая ам.доллар, өссөн дүнгээр | 4057.0 | 2156.0 | 3674.7 | 382 ▲ | - | - | 1901 ▲ |
| Нүүрсний экспорт | сая тонн, өссөн дүнгээр | 42.6 | 14.9 | 35.4 | 22% ▲ | - | - | 2.8 дахин ▲ |
| Зэсийн экспорт | мян.тонн, өссөн дүнгээр | 1022.3 | 976.8 | 891.3 | 3% ▲ | - | - | 5% ▼ |
| Төв банкны бодлогын хүү | хувь | 13% | 10% | 13% | 0% | - | 0% | 3% ▲ |
| Гадаад валютын нөөц | тэрбум ам.доллар | 3.93 | 2.69 | 3.83 | 3% ▲ | - | - | 46% ▲ |
| Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь | хувь | 8.59% | 11.3% | 8.77% | -0.18 нэгж хувиар ▼ | - | - | -2.44 нэгж хувиар ▼ |